

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

### "БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ӨСВӨР ҮЕ, ХҮҮХЭД ЗАЛУУСТ ЗОРИУЛСАН "ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ" ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТАЙЛАН

2023.03.20

Дархан-Уул аймаг

Хүүхэд, залуучуудад эх орноороо бахархах, итгэл үнэмшилтэй, биеэ зөв авч явах, багаар ажиллах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, амьдралын зөв дадал, чадварыг эзэмшүүлэх зорилгоор "БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" төслийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Залуучууд театрт "Эх оронч үзлийг төлөвшүүлэх нь" өдөрлөгийг Дархан-Уул аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, аймгийн Соёл, урлагийн газар, Зэвсэгт хүчний 330 дугаар анги, Залуучууд театр, Аймгийн музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон зэрэг байгууллагууд зохион байгууллаа. Мөн Боловсрол, шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн монгол, Улаан загалмайн хороо хамтран ажиллалаа. Тус өдөрлөгийг 10:00 цагаас 15:00 хүртэл Залуучууд театрт зохион байгуулж нийт 500 гаруй ахлах ангийн сурагчид хамрагдлаа.



#### Зохион байгуулсан үйл ажиллагаа:

1. "Бид эх орны ирээдүй" төслийн хоёрдугаар шатны нээлтийн "Эх оронч үзлийг төлөвшүүлэх нь" өдөрлөгийн нээлтийн үеэр лед дэлгэцийг ажиллуулж, фото зураг дарлаа.
2. Лекцийн дараагаар Залуучууд театрын уран бүтээлчид "Эх орны хүү" 25 минутын урлагийн тоглолт толилууллаа.
3. Нэг давхрын талбайд 10:00-15:00 цаг хүртэл
  - Аймгийн Музейгээс "Халх голын түүхэн ялалт" түр үзэсгэлэн болон "Байлдааны нисдэг цаасан онгоц хийх" боловсролын хөтөлбөр зохион байгуулж 30 гаруй насанд хүрэгч, 400 гаруй хүүхэд, боловсролын хөтөлбөрт 50 хүүхэд оролцож сурлаа.

- Аймгийн Төв номын сангийн зүгээс "Монгол цэргийн өдөр" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, уншигчийн үнэмлэх нээж, ном солилцоо хийлээ. Мөн "Бэлэгтэй асуулт" буланг ажиллуулж 18 хүүхдийг урамшуулав.
- Хүүхдийн номын ордноос "Бид эх орны ирээдүй" өдөрлөгийн хүрээнд "Монгол цэргийн өдөр"-т зориулан ХНО-ны сан хөмрөг дэх цэрэг эх орны сэдэвт номоор болон сан хөмрөгт шинээр ирсэн номуудыг олон нийтэд танилцуулах зорилгоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, тус номуудаар уншлага зохион байгуулж, 150 гаруй оролцогчдыг хамруулсан. Мөн уншигчийн картыг хөнгөлөлттэй үнээр нээж, 6 уншигч шинээр бүртгэлээ.
- Зэвсэгт хүчний 330 дугаар цэргийн ангиас сэдэвчилсэн үзэсгэлэн, фото зон, техник төхөөрөмжтэй танилцах хөтөлбөрийг зохион байгууллаа.
- Аймгийн Соёл, урлагийн газраас Ардын хувьсгалын 102 жилийн ойг бэлгэдэн 102 ахлах ангийн сурагчдын дунд "АХА" тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд оролцсон 102 хүүхэд бүрд чихэр, сүүлийн 20 хүүхдэд ном, 1, 2, 3 дугаар байранд шалгарсан сурагчдад өргөмжлөл дурсгалын зүйлийг гардууллаа.

Үйл ажиллагааны мэдээг Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар цахим хуудас болон салбар байгууллагууд өөрийн цахим хуудсуудад мэдээлэл нийтэлж ажиллалаа.



**ТАЙЛАНГ БИЧСЭН: УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ОТГОНБАЯР**